

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 5-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙГАЛИЙН ХОВОР УРГАМАЛ ТАРИАЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 2787172/

Агуулга

1	Төслийн товч танилцуулга	2
1.1	Төслийн зорилго	2
1.2	Төслийн байршил	2
1.3	Төсөл хэрэгжүүлэх үе шат	2
1.4	Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ	3
2	Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	3
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	5
4	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	8
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
6	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	11
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18
12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	19

1 Төслийн товч танилцуулга

1.1 Төслийн зорилго

Монгол улсдаа Анагаах ухаан, Экологи эдийн засгийн өндөр ач холбогдолтой эмийн түүхий эд, хоол хүнсний туслах найрлага болох Урал чихэр өвсийг “*Glycyrrhiza uralensis*” тариалж дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй гадаад орнууд руу экспортлох зорилготой.

1.2 Төслийн байршил

Төслийн нэр: Байгалийн ховор ургамал тарих


Төсөл хэрэгжүүлэх байгууллага: “Аялуун фарм” ХХК

Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар: РД:2787172, УБГ:9011047023

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дизайнер төв, Ард Аюушийн гудамж, Баянгол дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Хариуцсан ажилтны нэр, утас: Ц.Чингүнбат, 70003839

Төслийн байршил: Төслийн талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт, аймгийн төвөөс 5-6 км зайд байрлана.



1.3 Төсөл хэрэгжүүлэх үе шат

Төслийн талбайд 2019 оны 6-р сард Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний үндсэн дээр 2020 оноос эхлэн Байгалийн ургамлын тухай хуулийг мөрдөж ургамлын мэргэжлийн байгууллагад бүртгүүлэн шаардлагатай хашаа, худаг, тоног төхөөрөмж, түүхий эд материал, барилга байгууламж, ажиллах боловсон хүчин зэргийг бэлтгэсэний дараа туршилтын эмийн ургамлыг тариалж эхэлнэ гэж төлөвлөж байсан боловч дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахал гарсны улмаас төлөвлөгөөт

ажлууд хойшлогдож 2022 онд эзэмшлийн талбайг хашаажуулах болон худаг гаргах, шаардлагатай барилга байгууламжийг талбайд байршуулах ажлууд хийгдсэн бөгөөд 2023 оноос бусад төлөвлөгөөт ажлууд хийгдэнэ.

1.4 Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ

Дэлхийн ихэнх улсын чихэр өвсний үндэс байгалиас ухагдаж тухайн ургамлын нөөц хомсдож байна. Жишээ нь 1990 оны үед Хятад улс 8000-10000 тонн чихэр өвсийг үндэс болон шахмал байдлаар экспортлож байсан боловч, 2006 онд 3500 тонн болтлоо багасаж импорт нь 4000 тонн болж ихэссэн. Хятад улс нь эртнээс чихэр өвсний үндэс болон түүнээс гаралтай түүхий эдийг экспортлож ирсэн боловч одоогийн байдлаар өөрөө цэвэр импортлогч орон болсон. Энэ нь тус ургамлын хэрэгцээ ихэссэнтэй холбоотой биш Хятадын нөөц багассантай холбоотой юм.

Дэлхийн 4-ний нэгийг эзэлдэг Европд чихэр өвсний үндэсний хэрэгцээ ихсэж байна. 2017-2025 оны хооронд зах зээлийн өсөлт нь жилд 4%-иар өснө гэсэн таамаглал бий. Хүнсний нэмэлт бодис болон эмийн түүхий эд болох чихэр өвсний хэрэгцээ ихсэхийн зэрэгцээ байгалийн нөөц хомсдож эхлэж байна. Иймд чихэр өвсийг эх орондоо тариалж бага ч болтугай байгалийн нөөц баялагийг урьдчилан хамгаалж, байгаль дэлхийд хувь нэмрээ оруулахаар зорьж байна.

2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Газарзүйн мужлал: Төсөл хэрэгжих талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт, аймгийн төвөөс 5-6 км зайд байрлана. Хэрлэн сум нь Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн голын ай сав бүхий тал хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1031 м өндөрт оршдог. Физик газарзүйн мужлалын хувьд Монголын дорнод талын их мужийн, Халхын дундад ба Дарьгангын талархаг дэд мужийн, Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт, Байгалийн бүс, бүслүүрээрээ хээрийн бүсэд хамаарагдана.

Уур амьсгал: Хэнтий аймгийн нийт нутаг дэвсгэр нь хотгор гүдгэрийн ялгаа ихтэй учраас өвөл зуны температурын хэлбэлзэл их байна. Хамгийн дулаан сар 7 сар байх бөгөөд сарын дундаж температур $+18.8^{\circ}\text{C}$ байна. Үнэмлэхүй их температур нь $32.6-36.9^{\circ}\text{C}$ хүрч халах бөгөөд зарим жил $38.1-39.7^{\circ}\text{C}$ хүрч халдаг байна. Хөрсний гадарга дээр зундаа $64-69^{\circ}\text{C}$ хүртэл халж, өвөлдөө $-40-45^{\circ}\text{C}$ хүртэл хүйтэрдэг. Хаврын эцсийн цочир хүйтрэл 5-р сарын сүүлчээр, намрын эхний цочир хүйтрэл 9-р сарын 10-аар тохиолдох учир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110 хоног байна. 0°C -ээс дээш температуртай хоногийн тоо жилдээ 193, 10°C -ээс дээш температуртай хоногийн тоо жилдээ 126 хоног буюу ургамал ургалтын хугацааны дулааны нөөц нэн хангалттай байна. Чингис хотод жилдээ 265 мм орчим хур тунадас орох бөгөөд хур тунадасны 92 орчим хувь нь жилийн дулаан улирал буюу 4-9-р саруудад орно. Жилдээ дунджаар 22 өдөр аянга цахилгаантай бороо ордог ба хамгийн олондоо 40 өдөр хүрч байжээ. Жилийн дундаж салхины хурд 3.6 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.8-4.7 м/с байдаг.

Гадаргын ус: Төслийн талбайн нь ус зүйн мужлалаар Номхон далайн ай сав, Сав газраар Хэрлэн голын сав газарт орно. Төслийн талбайгаас урд зүгт 2.3 км зайд Хэрлэн гол байна.

Газрын доорх ус: Газрын доорх усны их нөөцтэй талбай нь Хэрлэн голын татам дагуу, Онон, Балж, Хурх, Барх голуудын өргөшсөн татам болон зарим жижгэвтэр голуудын хөндийд орших нуур, аллювийн хурдас тархсан өргөшсөн хэсгүүдийг эзлэн байрлана. Эдгээр талбайд зонхилон тархсан аллювийн хурдасны зузаан нь их ус дамжуулах чадвар нь $40-3500\text{ м}^2/\text{хоног}$ хүртэл хэмжээнд хэлбэлздэг, дундаж хэмжээ нь 300 орчим $\text{м}^2/\text{хоног}$ байна. Газрын доорх усны урсац их $120-150\text{мм}/\text{жил}/$ бөгөөд тухайн орчимд гаргасан 45

худгийн материалыг үндэслэн хийсэн тооцоогоор газрын доорх усны модуль нь 0.41-0.96 л/с*км² байна.

Хөрс: Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өргөргийн бүсшилтэй нутгийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Өндөрхаан-Түмэнцогтын тойрогт хамрагдаж байна. Судалгааны талбайд нэлэнхүйдээ хүрэн шороон хэв шинжийн хөрсний дэд хэв шинж болох жинхэнэ хүрэн хөрс тархсан байна.

Ургамал: Монгол орны нутаг дэвсгэрийн 25.85%-ийг эзлэх хуурай хээрийн бүсэд хамаарах ба ургамал газар зүйн мужлалаар манай улсын нийт нутаг дэвсгэрийн 11.54%-ийг эзэлж, одоогоор 500-аас дээш зүйл ургамал агуулсан Дундад Халхын хээрийн тойрогт хамаарч байна. Төслийн талбайн ургамалшилт олон арван жил суурьшил, бэлчээр, тариаланд маш их талхлагдсан, байгалийн унаган төрхөө олоогүй буюу атаршсан шинжээрээ байна.

Амьтан: Амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Хэнтийн дэд муж, Хэнтийн гол нурууны тойрогт хамрагдана. Энэхүү бүс нутаг нь амьтны аймгийн бүрдлийн хувьд хээрийн амьтад зонхилон тархсан байдаг. Төслийн талбай түүний ойр орчмын гадаргын төрх байдал, ургамлан нөмрөгийн байдлаас үзэхэд үхэр, адуу олноороо байнга бэлчдэг нутаг тул ургамлан нөмрөг доройтсон, хөл газрын ургамал ихтэй болсон тул шавжийн аймгийн бүрэлдүүнээр тийм ч баялаг биш байна. Энд шулуун далавчтан (царцаа, голио), цох (Coleoptera), эрвээхий (Lepidoptera), хальсан далавчтан Hymenoptera (зөгий, шоргоолж), ялаа (Diptera) зэрэг олон багийн олон зүйл шавж амьдарч байгалийн бодисын эргэлт, оршин тогтноход чухал үүрэг гүйцэтгэнэ. 4 багийн 18 зүйл шувуу тохиолдохоос боршувуутаны багийн шувуу олон (11 зүйл) зүйл байдаг ба суурин амьдарч тал хувь нь хүнд ойромсог шувуунд тооцогддог. Тус нутагт тархалт нь тэмдэглэгдсэн 3 багийн 11 зүйл хөхтөн амьтан амьдрах боломжтой.

Газар ашиглалт: Хэрлэн сумын газар нутаг нийт 380,878.0 га талбайтай үүнээс Хөдөө аж ахуйн газар 363,569.9 га буюу 95.46%, Хот, тосгон бусад суурины газар 14,604.4 га буюу 3.83%, Зам, шугам сүлжээний газар 2,378.2 га буюу 0.62 %, Усны сан бүхий газар 321 га буюу 0.08%, Улсын тусгай хэрэгцээний газар 4.5 га 0.001%-г тус тус эзэлж байна. ХАА-н газраас хамгийн их хувийг бэлчээрийн зориулалттай газар эзлэх ба 4.28%-ийг тариалан, 2.66%-ийг хадлан, 2.41%-ийг атаршсан талбай эзэлж байна.

Нийгэм, эдийн засгийн байдал: Хэрлэн сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болсон Хэрлэн, Булаг, Баянмөнх, Сариг, Өндөрхаан, Цогт-Өндөр, Номгон, Ишгэн толгой гэсэн 8 багтай. 2018 оны жилийн эцсийн байдлаар 7552 өрхийн 23671 хүн ам амьдарч байна. Хүн амын хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэйчүүд давамгайлах хандлагатай байна. 2014 оноос хойш нийт өрхийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд үүнийгээ дагаад сумын төвийн суурьшил нэмэгдэж байна.

2014-2018 оныг харьцуулан үзэхэд ажилгүй иргэдийн тоо буурсан хандлагатай байгаа хэдий ч ажил эрхлэх боломжит насны иргэдийн /25-29 нас/ тоо өссөн байна. 2018 онд Хэрлэн суманд 487.55 мянган мал тоологдсон ба үүнээс тэмээ 0.42, адуу 28.89, үхэр 33.29, хонь 245.94, ямаа 179.03 мянган толгой тус тус тоологджээ. Сүргийн бүтцийн хувьд авч үзвэл ямаа, хонин сүрэг дийлэнх хувийг эзлэнэ. Сүүлийн 5 жилийн хугацаанд тариалан эрхлэлт буурах хандлага ажиглагдсан боловч ургац хураалтын хэмжээ 2018 онд хамгийн өндөр байна.

Хэрлэн сумын хэмжээнд бүртгэлтэй 700 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бий. Ихэвчлэн нийтийн ахуй үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл, гар урлал, сүү сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний үйлдвэрлэлээр данган үйл ажиллагаа явуулж байна.

3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчны бүрдэл тус бүрээр төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэхэд **30%** буюу **нөлөөлөлгүй**, **50%** буюу **бага** нөлөөлөлтэй, **20%** буюу **дунд** нөлөөлөлтэй гэж үнэлэгдлээ. Төслийн үйл ажиллагаанаас их болон хүчтэй нөлөөлөл үүсэхгүй ба ерөнхийд нь дүгнэвэл байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл “**Бага**” гэж үнэлэгдхээр байна.

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бусад бүрдэл хэсгүүдээс их байгаа боловч энэ нь тодорхой цэгт, бага хэмжээний нөлөөлөл үүсгэнэ.

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар					Тайлбар
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй	
Агаарын чанар						
Хүйтний улиралд барилга байгууламжийг түлж түлж халаахад агаарт бохирдуулагч бодис /SO ₂ , NO ₂ , CO/ ялгарах	+					Дулаан хангамжаа цахилгаан халаалтаар шийдэх учир агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй.
Шороон замаар тээвэрлэлт хийх, газар хагалах үед богино хугацаанд тухайн орчны агаарт тоосжилт үүсэх		+				Төслийн эхний үе шатанд сумын төвөөс төслийн талбай хүртэлх шороон замаар тээвэрлэлт хийх ба энэ нь тодорхой цэгт, богино хугацаанд тоосжилт үүсгэнэ. Цаашид хатуу хучилттай зам тавих учир энэхүү нөлөөлөл арилна.
Гадаргын болон газрын доорх ус						
Удаан хугацааны турш худгаас ус авч ашиглахад газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах		+				Ундны усыг цэвэршүүлсэн баллонтой усаар, ахуйн хэрэглээний усыг төслийн талбайд гаргасан худгаас хангахаар төлөвлөсөн. Харин усалгаанд хэрэглэх усыг Хэрлэн голоос зөөвөрлөн ирж ашиглах боломжтой.
Газрын гадарга, хөрс						
Барилга байгууламж барих, зам талбай тавих, тариалангийн талбай хагалах үед хөрс доройтох, дарагдах, эвдрэлд орох			+			Төслийн G4 талбайд агуулах, оффисын байр зэргийг 225 м ² талбайд барих үед газрын гадарга эвдрэлд орно. Газар хагалах, ургац хураах үед хөрс бүтцээ алдана.
Гадаргын төрх байдал өөрчлөгдөх		+				Гадаргын төрх байдал төдийлөн өөрчлөлтөнд орохгүй, өнгөн хэсэг нь эвдрэлд орно.
Шатах тослох материал асгарч алдагдсанаас хөрс бохирдох		+				Үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгслийн эвдрэл гэмтлээс үүдэн гэнэтийн асгаралт үүссэнээр хөрс бохирдож болзошгүй.
Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг ил задгай асгаснаар хөрс бохирдох	+					Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг танканд цуглуулж, тухай бүрт соруулан аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх учир газрын доорх ус, хөрсний бохирдол үүсгэхгүй.

Пестицид, гербицид хэрэглэснээр хөрсний бохирдол үүсгэх	+					Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор химийн найрлага бүхий бодис, бордоо ашиглахгүй органик бордоо хэрэглэх тул хөрсийг бохирдуулахгүй.
Ургамал						
Ургамлан бүрхэвч гэмтэх, дарагдах, талхлагдах, устах			+			Барилга байгууламж барих, газар хагалах үед ургамлан бүрхэвч устаж үгүй болно.
Амьтан						
Мэрэгч, шавжийн амьдрах орчин хумигдах		+				Төслийн талбайд үлийн цагаан оготно элбэг тархсан байгаа бөгөөд тариалалт эхлэх үед эдгээр хортон мэрэгчдийг мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэж тоо толгойг нь багасгахаар төлөвлөсөн байна.
Нийлбэр оноо	3	5	2			

4 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Аялуун фарм ХХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2019 онд “ЖЭМР” ХХК-ийн боловсруулсан “Байгалийн ховор ургамал тариалах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэв.

“Аялуун фарм” ХХК нь 2023 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд нийт 20.6 сая төгрөг зарцуулахаар төсөвлөлөө.

№	Хийгдэх ажлын чиглэл	Нийт зардал, ₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,000,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,500,000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,000,000
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,748,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,325,400
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,000,000
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3,000,000
Нийт		20,573,400

5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Тоо хэмжээ	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нүхэн жорлон ашигласнаар хөрсний бохирдол үүсгэх	Соруулдаг “Эко” нүхэн жорлон барьж ашиглах	Эзэмшлийн талбайд	ш	Үйл ажиллагааны зардал	1	-	Төсөл эхлэх үед	MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ, MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
2	Газар доорх усыг ариг гамгүй ашиглах	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан заасан хэмжээнд ашиглах	Худаг	ш	-	2	-	Ус авч ашиглахаас өмнө	Усны тухай хууль
3		Ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулан акт үйлдэн усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд төлөх			-	2	-		
4		Усны тоолуур суурилуулах			1,000,000	4	4,000,000		
5	Газрын доорх усны чанар, найрлага өөрчлөгдөх	Худгийн байр барих, тоноглох, эрүүл ахуйн бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх	Худаг	ш	-	2	-	Худаг гаргасны дараа	Усны тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Тоо хэмжээ	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
6	Өмнө ашиглаж байсан шороон зам хаагдснаар шинээр зам гарч хөрс, ургамал талхлагдах	Олон салаа зам гаргахаас сэргийлж гол шороон зам дээр замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Эзэмшлийн талбайн баруун болон баруун, зүүн хойд талд	ш	Үйл ажиллагааны зардал	3	-	Төслийн явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
Нийт							4,000,000		

6 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ногоон байгууламж бий болгох	Тухайн газрын орчин нөхцөлд ургах боломжтой мод бут тарих	Эзэмшлийн талбай	ш	4000	Үйл ажиллагааны зардал		Бүх нийтийн мод тарих өдөр	Газрын тухай хууль, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2	Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Хайлаас, голт бор тарих, арчилгаа тордолгоог хийх, суманд хүлээлгэн өгөх	Зам дагуу	ш	2000	Үйл ажиллагааны зардал		Бүх нийтийн мод тарих өдөр	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
3	Хөрс хамгаалах, үржил шимийг сайжруулах	Хөрсийг мал амьтны гаралтай эко бордоогоор бордох	Эзэмшлийн талбай	га	10	50,000	500,000	5-6 сард	Тариалангийн тухай хууль
4		Олон наст тэжээлийн ургамал тарьж хөрсний үржил шимийг дээшлүүлэх		га	10	-			
5	Эмийн ховор ургамал тарималжуулахад орон нутгийн иргэдийг оролцуулах	Хүлэмжинд тарималжуулах туршилт судалгааны ажлыг эхлүүлэх	Хүлэмжийн аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжтэй хамтран зохион байгуулах	ш	10	100,000	1,000,000	9-4 сард	Байгалийн ургамлын тухай

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
6		Ургамлын үрсэлгээг гадна талбайд шилжүүлэн суулгах, арчилгаа тордолгоо хийх	Хагалсан талбай	га	1		-	5-8 сард	
Нийт							1,500,000		

7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Эзэмшлийн талбай нь өмнө тариалангийн зориулалтаар ашиглаж байгаад атар газар болгосон учир түүх соёлын дурсгалт олдвор байхгүй болно.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Нөлөөлөлд өртөх соёлын өв байхгүй	-	-	-	-	-	-	Соёлын өвийн тухай хууль
Нийт								

8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Газар хагалах, усалгаа хийх, тоног төхөөрөмж угсрах, хураах үед хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглээгүйн улмаас бэртэх, гэмтэх	Ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах	Ажиллагсад	5	400,000	2,000,000	Ажил эхлэх үед	Хөдөлмөрийн тухай хууль
	Нийт	-	-	-	-	2,000,000	-	-

9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хатуу хог хаягдал	Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх	-	ш	1	48,000	48,000	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, 2012
2		Хог хаягдлын ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулах /тэмдэг тэмдэглэгээтэй, бороо цасны усанд норхоггүй, салхинд хийсэхгүй тагтай, хөрсөнд шингэхгүй бетонон суурьтай/	Манаачийн гэрийн урд	ш	1	Үйл ажиллагааны зардал		Төсөл эхлэх үед	
3		Салхиар зөөгдөн ирсэн хог хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэж байх	Хашаан дотор болон гадна талд	Удаа	24	50,000	1,200,000	Сард 2 удаа	
4		Эзэмшлийн талбайд өмнө хаягдсан хог хаягдлыг цэвэрлэж зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах	Эзэмшлийн талбай	Удаа	4	50,000	200,000	3-5 сард	
5	Ахуйн шингэн хог хаягдал	Бохир усыг дүүрэхээс өмнө зориулалтын тээврийн хэрэгслээр соруулж аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх	Эко жорлон	Удаа	2	150,000	300,000	Жилд 2 удаа	MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
6	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн хог хаягдал гарахгүй	-	-	-	-	-	-	Хог хаягдлын тухай хууль, 2012
7	Аюултай	Үйл ажиллагааны үед аюултай хог үүсэхгүй	-	-	-	-	-	-	Хог хаягдлын тухай хууль, 2012
Нийт						-	1,748,000		

10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Тайлбар	Баримлах эрзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Аэрозол: Нийт тоос	Эзэмшлийн талбайн салхин дээд, доод, төвд болон Оффис, манаачийн байр, худаг, тариалалт хийх талбай гэсэн нийт 10 цэг	Жилд 2 удаа, (IV, X сард)	20	15,000	300,000	Dust Trak тоосны ширхэглэг хэмжих багаж	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ /NO ₂ , SO ₂ /			20	35,000	700,000	HAZ-SCANNER model HIM-6000	
3	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт			20	10,000	200,000	DT-8820 Environment meter дуу шуугианы түвшин хэмжигч	
4	Усны ерөнхий үзүүлэлт	2 худаг	Жилд 1 удаа	2	49,000	98,000	Усны дээжний сав хэмжээ: 1000 мл лабораторийн шинжилгээ	MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
5	Усны хүнд металын шинжилгээ			2	78,000	156,000		
6	Усны бактерлогийн шинжилгээ			2	49,700	99,400		MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Тайлбар	Баримлах эрзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
7	Хөрсний физикийн үзүүлэлт	Хими-ерөнхий	Жилд 2 удаа (V, X сард)	12	30,000	360,000	Хөрсний дээж авах зиптэй уутны хэмжээ: 1000 гр, лабораторийн шинжилгээ	MNS 2305:1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
8	Хөрсний ахуйн үзүүлэлт	эрүүл		4	33,000	132,000		MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
9	Хөрсний металлын үзүүлэлт	хүнд		8	35,000	280,000		MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
10	Ургамлын мониторинг	Эзэмшлийн талбай болон талбайн гадна талд	Жилд 1 удаа	1	1,000,000	1,000,000	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Байгалийн ургамлын тухай хууль
Нийт						3,325,400		

11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			I-р улирал	II-р улирал	III-р улирал	IV-р улирал		
	1	2	3	4	5	6	7	8
1	Чихэр өвсний үрний нөөц бүрдүүлэх судалгаа хийх	Үйл ажиллагааны зардлаар		Баянхонгор, Говь-Алтай аймгуудад			Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Ургамлын мэргэжлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, мэдээлэл бүрдүүлэх
2	Чихэр өвс тариалах төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	1, 2-р сард				Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Дотоод зохион байгуулалтаар хийх
3	Нутгийн иргэдэд эмийн ургамал үрээр үрслүүлэх, ургуулах чиглэлээр дотоод сургалт явуулах	Үйл ажиллагааны зардлаар	3-р сард				Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Орон нутагтай хамтран ажиллах
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	5,000,000		4 сард		10 сард	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
5	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон 2024 оны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах	Үйл ажиллагааны зардлаар				10-11 сард	-	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
	Нийт	5,000,000						

12 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, ₮	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Багийн иргэд	Танхим	2023 оны батлагдсан БОМТ-г танилцуулах	IV сард	1,000,000	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Хэрлэн сумын соёлын төв
2	Сумын удирдлага болон хот тохижилтын газар	Танхим	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулах, хүлээлгэн өгөх	IV-V сар	1,000,000	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Сумын ЗДТГ, мод тарьсан газар
3	Сумын удирдлага, багийн иргэд	Танхим	2023 онд байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлыг тайлагнах, 2024 оны төлөвлөгөөнд тусгах санал авах	XI сар	1,000,000	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан	Хэрлэн сумын соёлын төв
Нийт					3,000,000		